



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 06 сарын 15 өдөр

Дугаар 1/316

Мандалговь

Г Баталгаажуулалтанд хамруулах тухай

Монгол улсын Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1 дэх заалт, Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуй нэгж, байгууллагуудын барилгын материал, бүтээгдэхүүнийг баталгаажуулалтанд хамруулах “Тохирлын гэрчилгээ”-тэй болгох ажлыг зохион байгуулах, арга зүйн зөвлөгөө өгөх ажлыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Э.Чагнаадорж/-т, Стандартчилал хэмжил зүйн хэлтэс /А.Пүрэвсүрэн/-т тус тус үүрэг болгосугай.

2. Барилга байгууламж барих, шинэчлэх, өргөтгөх, засварлах ажилд олон улсын болон үндэсний стандартын шаардлага хангасан, гарал үүсэл, тохирлын гэрчилгээтэй материал, бүтээгдэхүүн, эдлэхүүнийг хэрэглэхэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар /Ш.Төрбат/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ



0200621